

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧААСАЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
НАРТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ БИЕЛЭЛТ**

Аймгийн Засаг дарга нартай 2016 онд хамтран ажиллах гэрээг 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан. Нийт 16аймгийн Засаг дарга гэрээний биелэлтээ албажуулан ирүүлсэн бөгөөд гэрээний биелэлтэд жилийн эцсийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын 2013 оны 322 дугаар тогтоолоор баталсан журмын дагуу гүйцэтгэв.Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Хөвсгөл аймгуудаас хамтран ажиллах гэрээний биелэлтийг баталгаажуулж ирүүлээгүй тул "0" хувиар дүгнэсэн болно.

Хамтран ажиллах гэрээний хэрэгжилтэнд өгсөн үнэлгээний үзүүлэлтийг хүснэгтээр үзүүлэв. Ерөнхий үнэлгээ **65.5** хувьтай.

Аймгийн Засаг дарга нартай байгуулсан хамтран
ажиллах гэрээний биелэлтэд өгсөн үнэлгээ

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

ДД	Аймгийн нэр	Засаг даргын нэр	Гэрээний дугаар	Заалтын тоо	Дүгнэсэн арга хэмжээний биелэлт, хувь							Дүгнээгүй	Биелэлт, хувь
					100	90	70	50	30	10	0		
1	Архангай	Д.Бат-Эрдэнэ	1	11	5	1	1	-	-	-	-	3	94.3
2	Баян-Өлгий	Х.Дармен	2	11	6	1	-	1	-	-	-	2	92.5
3	Баянхонгор	Д.Жаргалсайхан	3	11	7	1	2	-	-	-	-	1	93.0
4	Булган	Д.Эрдэнэбат	4	11									0
5	Говь-Алтай	О.Амгаланбаатар	5	11									0
6	Говьсүмбэр	Л.Одсэр	6	11	2	7	4	-	-	-	-	4	85.4
7	Дархан-Уул	А.Энхболд	7	11	4	2	1	1	-	-	-	-	87.5
8	Дорноговь	П.Ганхуяг	8	11									0
9	Дорнод	М.Бадамсүрэн	9	11									0
10	Дундговь	С.Од-Эрдэнэ	10	11	3	4	2	-	-	-	-	2	88.9
11	Завхан	Ж.Жамъянтив	11	11	5	2	2	-	-	-	-	2	91.1
12	Орхон	С.Дангаасүрэн	12	11	3	3	1	1	-	-	-	3	86.3
13	Өвөрхангай	Д.Тогтохсүрэн	13	11	4	3	2	-	-	-	-	1	90.0
14	Өмнөговь	Б.Бадраа	14	11	3	5	1	2	-	-	-	-	79.1
15	Сүхбаатар	Ж.Батсуурь	15	11	6	1	1	1	-	-	1	1	81.0
16	Сэлэнгэ	С.Бүрэнбат	16	11	4	4	-	2	-	-	-	1	86.0
17	Төв	Д.Баярбат	17	11	5	2	1	-	-	-	1	2	83.3
18	Увс	Д.Цэндсүрэн	18	11	1	3	1	1	-	-	-	-	81.6
19	Ховд	Д.Цэвээнравдан	19	11	4	4	-	-	-	-	1	2	84.4
20	Хөвсгөл	А.Эрдэнэбаатар	20	11									0
21	Хэнтий	Ж.Оюунбаатар	21	11	2	1	2	-	-	-	1	4	71.6
НИЙТ													65.5

ДҮГНЭЛТ

Уул уурхайн сайдын аймгийн Засаг дарга нартай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах нийтлэг зөрчил, дутагдал илэрч байна. Үүнд:

1. Геологи хайгуул болон газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг харгалзан үзэж тухайн аймагтай хамтран ажиллах гэрээг байгуулах шаардлагатай байна.

2. Ашигт малтмалын газрын /хуучнаар/ зүгээс Төв аймгийн нутаг дэвсгэрт санал авалгүй 12, орон нутгаас татгалзсан /дэмжихгүй/ 66 хариу хүргүүлсэн боловч хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон мэдээллийг ирүүлсэн байна.

3. Ашигт малтмал эрэх хайх талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн саналд хууль тогтоомжийн дагуу хариу шуурхай хүргүүлэх арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа Завхан, Архангай, Өвөрхангай, Орхон, Дархан-Уул, Ховд зэрэг аймгууд орон нутагт хэдэн санал ирсэн, хэдэн саналыг дэмжсэн болон дэмжээгүй талаар тодорхой тоон мэдээллийг тусгаагүй байна.

4. Засаг дарга нар хамтран ажиллах гэрээний хэрэгжилтийг бичихдээ аль суманд ямар аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж байгаа нь тодорхойгүй, тухайн заалтад дурдсан арга хэмжээнд холбогдолгүй болон сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамааралгүй арга хэмжээг тоочих, заалтын хүрээнд хийсэн ажлын хэмжээ харагдахгүй хэт ерөнхийлөн бичих, тухайн аймагт үйл ажиллагаа явуулж буй нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг бүрэн хамруулсан эсэх нь тодорхойгүй тайлагнасан байна.

5. Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Хөвсгөл аймгуудаас хамтран ажиллах гэрээний биелэлтийг баталгаажуулж ирүүлээгүй нь Архивын ерөнхий газрын даргын "Албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар батлах тухай" 2009 оны 68 дугаар тушаалын

2.2.1-т: "Төр, захиргааны байгууллагын албан баримт бичгийг стандартын шаардлагын дагуу хэвлэлийн аргаар бэлтгэсэн, төрийн сүлд, соёмбо бүхий хэвлэмэл хуудсан дээр, аж ахуйн нэгж, компанийн албан баримт бичгийг бэлэгдэл тэмдэг, лого бүхий хэвлэмэл хуудсан дээр үйлдэнэ",

2.3.10-т: Бусад байгууллагад явуулж буй баримт бичигт байгууллагын дарга буюу орлогч, зохион байгуулалтын нэгжийн дарга байгууллагын дүрэм, дотоод журмаар тодорхойлогдсон эрх үүргийн дагуу гарын үсэг зурна, Төлөвлөгөө, тайлан, удирдамж, танилцуулгазэрэгмэдээлэл-лавлагааны шинж чанартай баримт бичигт зохион байгуулалтын нэгжийн болон албан тушаалын нэрээ зааж, боловсруулсан ажилтан гарын үсэг зурна",

2.3.12-т: "Баримт бичгийн албан ёсны хүчин төгөлдөр байдал болон албан тушаалтны гарын үсгийг тамга, тэмдэг дарж, баталгаажуулна. Байгууллагын тамгыг дарга, орлогчийн, байгууллагын тэмдгийг зохион байгуулалтын нэгжийн даргын гарын

үсэг зурсан баримт бичиг дээр дарна" гэсэн заалтуудыг зөрчсөн тул тус тайлангуудад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгээгүй болно.

САНАЛ ЗӨВЛӨМЖ

1. Хамтран ажиллах гэрээний биелэлтэд ач холбогдол өгч, гэрээний заалт бүрээр хийсэн ажил, биелэлтийг оновчтой, тодорхой, хэрэгжүүлсэн субъект, албан бичиг хүргүүлсэн огноо, дугаартайгаар үнэн зөв гаргаж ирүүлж хэвших.
2. Гэрээний заалтад хамааралгүй болон дутуу биелэлт бичих, утга найруулга, үг үсгийн алдаатай бичих зэрэг зөрчлүүд гарч байгаад анхаарах
3. Тухайн зорилт, арга хэмжээний гол үр дүн, хүрсэн түвшин, төлөвлөсөн асуудалтай уялдуулж ажлаа тайлагнах тал дээр анхаарч ажиллах.
4. Хамтран ажиллах гэрээг байгуулахдаа дээр дурдсан зөрчил дутагдлуудыг арилгахтал дээр Төрийн захиргааны удирдлагын газар анхаарч ажиллах.
5. Хамтран ажиллах гэрээг дүгнэх, хэрхэн тайлагнах талаар орон нутгийн холбогдох албан тушаалтнуудад төсөл, хөтөлбөрийн хүрээнд сургалт зохион байгуулах.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР